



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 57373

Улаанбаатар хот

Б.Лхамноржинд сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27.4.3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7, 37.1.13 дахь заалт 48 дугаар зүйлийн 48.1.4 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 6.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1, 10.4, 10.9, 10.10, 10.10.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Бямбаагийн Лхамноржин нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчийн 2023 оны 2755 дугаартай дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнийг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсугай.
- 2.Б.Лхамноржингийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар /Н.Наранцэцэг/-т даалгасугай.
- 3.Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нууц хамгаалах ажилтан /Г.Анхныбаяр/-д үүрэг болгосугай.
- 4.Б.Лхамноржингийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцэж, 11/81 дугаартай улсын ахлах бүртгэгчийн тэмдгийг хураан авч түр хадгалахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.
- 5.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142302121